

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих ангийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/14-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Цогт Утас: 7036-3036 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn
---	--

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13-14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-16
4. Аудитын тайлан	16-18
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17-18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
5. Аудитын илрүүлэлт	19-21
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ШШГЕГ-ЫН ХАРЬЯА 433 ДУГААР
ХААЛТТАЙ ХОРИХ АНГИЙН ДАРГА,
ХУРАНДАА Л.ЭРДЭНЭБАТ ТАНАА

2024.02.15 № СЭА-2024/14-НА-СЭА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 288.6 дахь заалтыг үндэслэн ШШГЕГ-ын даргын 2023 оны А/47 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа аймгийн төвөөс бусад суманд байрлаж буй анги, салбаруудад тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа албан хаагчдад 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох” шийдвэр гаргасан байна. Энэхүү шийдвэрийн дагуу тайлант онд нийт 45 албан хаагчид 823,072.6 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Дээрх мөнгөн урамшуулал болон Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосноос голлон шалтгаалж тус газрын 2023 оны нийт зардал өмнөх оноос 52.5 хувиар нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд орсон өөрчлөлтийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага болсон. Төрийн цэргийн байгууллагад хамрагдах эрх зүйн орчин бүрдсэнээр байгууллагын статус, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн эрх зүйн байдал цэргийн албаны чиглэлээр батлагдсан хууль, дүрэм журмыг мөрдөх үндсэн нөхцөл бүрдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус ангийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 100.0 хувьтай тайлагнаснаас 94.5 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	822,768,260.55	505,835,622.78
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,767,531.00	18,623,373.37
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,767,531.00	18,623,373.37
3121	Төгрөг	3,767,531.00	18,623,373.37
31211	Төрийн сангийн харилцах	3,767,531.00	18,623,373.37
33	АВЛАГА	9,147,600.00	-
335	Бусад авлага	9,147,600.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	9,147,600.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	809,853,129.55	487,212,249.41
351	Түүхий эд материал	83,200,727.19	75,934,388.60
35110	Тусгай зориулалттай материал	23,539,880.00	18,715,848.00
35130	Эм боох материал	3,433,204.57	3,252,861.66
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	2,129,858.11	7,992,396.97
35300	Бэлэн бүтээгдэхүүн	54,097,784.51	45,973,231.37
354	Хангамжийн материал	726,652,402.36	411,277,860.81
35410	Бичиг хэргийн материал	652,202.00	1,122,400.00
35420	Аж ахуйн материал	58,031,592.71	50,046,142.70
35430	Сэлбэг хэрэгсэл	522,000.00	971,000.00
35440	Түлш, шатах тослох материал	10,018,729.04	19,768,636.35
35450	Барилгын засварын материал	88,548,933.20	50,006,443.68
35460	Хүнсний материал	16,804,279.21	37,426,798.87
35470	Бусад хангамжийн материал	330,284,666.20	21,701,439.21
35600	Мал амьтад	221,790,000.00	230,235,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,313,615,187.70	6,497,977,108.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,313,615,187.70	6,497,977,108.87
392	Биет хөрөнгө	1,233,388,354.08	1,418,037,191.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,356,626,444.92	1,356,626,444.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	(603,520,897.97)	(661,463,962.11)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	459,358,990.89	439,906,150.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(337,052,110.93)	(344,882,815.98)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	400,923,695.01	716,495,153.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(150,661,448.43)	(199,709,168.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,105,212.00	49,947,212.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,898,445.83)	(20,127,820.11)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	15,463,660.00	15,463,660.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	36,738,609.00	36,538,609.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(16,785,829.58)	(19,878,345.65)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	42,090,475.00	49,122,075.00
393	Биет бус хөрөнгө	5,080,226,833.62	5,079,939,916.99
39301	Программ хангамж	4,437,692.31	4,437,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,550,858.69)	(3,837,775.32)

39303	Бусад биет бус хөрөнгө	5,079,340,000.00	5,079,340,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,136,383,448.25	7,003,812,731.65
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	17,498,531.00	19,002,886.59
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	17,498,531.00	19,002,886.59
413	Өглөг	17,498,531.00	19,002,886.59
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,970,056.53
4136	Бусад өглөг	17,498,531.00	17,032,830.06
41361	Байгууллагад төлөх өглөг	16,020,000.00	16,020,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,478,531.00	1,012,830.06
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,118,884,917.25	6,984,809,845.06
51	Засгийн газрын хувь оролцоо	7,118,884,917.25	6,984,809,845.06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,354,710,670.66	5,354,710,670.66
51101	Өмч: - төрийн	5,354,710,670.66	5,354,710,670.66
512	Хуримтлагдсан үр дүн	885,397,106.62	751,322,034.43
51210	Өмнөх үеийн үр дүн	885,397,106.62	885,397,106.62
51220	Тайлант үеийн үр дүн		(134,075,072.19)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	878,777,139.97	878,777,139.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,136,383,448.25	7,003,812,731.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,041,740,753.53	4,311,570,115.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,322,182,053.53	585,601,915.83
120	Нийтлэг татварын бус орлого	1,319,182,053.53	585,601,915.83
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,319,182,053.53	585,601,915.83
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	591,700,100.82	472,272,551.03
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	727,481,952.71	113,329,364.80
122	Тусламжийн орлого	3,000,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	3,000,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,719,558,700.00	3,725,968,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,717,308,700.00	3,685,968,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,717,308,700.00	3,685,968,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,250,000.00	40,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,250,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		40,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,332,807,738.32	4,445,645,188.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,332,807,738.32	4,445,645,188.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,267,922,903.36	3,322,453,488.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,132,073,971.97	1,847,048,635.94
210101	Үндсэн цалин	719,855,696.27	1,195,463,652.87
210102	Нэмэгдэл	393,792,122.06	611,677,983.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт		10,750,500.00

210104	Урамшуулал	18,426,153.64	29,156,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,633,275.08	35,405,532.82
210201	Тэтгэврийн даатгал	1,193,129.97	2,960,089.57
210202	Тэтгэмжийн даатгал	140,368.22	348,245.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	112,294.58	288,520.67
210204	Ажилгүйдлийн даатгал	28,073.67	69,649.18
210205	Эрүүл мэндийн даатгал	23,159,408.64	31,739,027.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	176,981,927.58	252,563,373.72
210301	Гэрэл, цахилгаан	106,239,446.58	146,489,108.23
210302	Түлш, халаалт	70,742,481.00	106,074,765.49
2104	Хангамж, бараа материалын зардал	330,210,670.98	364,003,632.01
210401	Бичиг хэрэг	5,808,516.00	7,264,602.00
210402	Тээвэр, шатахуун	65,460,609.83	66,800,673.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,215,804.28	3,448,634.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		146,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,980,680.00	6,187,058.90
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	235,377,541.79	250,171,651.16
210408	Бараа материал акталсны зардал	12,367,519.08	29,985,006.95
2105	Нормативт зардал	308,769,309.10	397,462,621.25
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,235,674.92	15,438,612.91
210502	Хоол, хүнс	278,627,143.18	368,869,285.84
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,906,491.00	13,154,722.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,084,260.80	201,139,619.52
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,040,300.00	4,687,200.00
210604	Урсгал засвар	48,043,960.80	196,452,419.52
2107	Томилолт, зочны зардал	-	2,465,400.00
210702	Дотоод албан томилолт		2,465,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,376,740.00	11,618,785.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,473,330.00	4,492,800.05
210803	Даатгалын үйлчилгээ	672,400.00	467,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	514,900.00	324,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	351,900.00	180,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	318,200.00	4,488,600.00
210807	Газрын төлбөр	1,046,010.00	1,665,385.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	218,792,747.85	210,751,387.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,167,334.30	18,672,388.88
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		383,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	205,625,413.55	191,695,198.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,884,834.96	1,123,185,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,404,900.00	1,068,160,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,755,000.00	2,175,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		232,671,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		823,072,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,649,900.00	10,240,800.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	479,934.96	500.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	479,934.96	500.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	55,000,000.00	55,025,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,000,000.00	55,025,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	708,933,615.21	(134,075,072.19)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	725,953.24	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.12	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	725,953.12	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(725,953.24)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	708,207,061.97	(134,075,072.19)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,427,483,827.82	4,183,131,810.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	647,330,562.78	457,164,110.77
120	Нийтлэг татварын бус орлого	647,330,562.78	457,164,110.77
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	645,041,562.78	434,178,167.46
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	645,041,562.78	434,178,167.46
120009	Бусад орлого	2,289,000.00	22,985,943.31
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,780,633,290.00	3,725,968,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,731,023,900.00	3,685,968,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,717,308,700.00	3,685,968,200.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	13,715,200.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,609,300.00	40,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,250,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,359,300.00	40,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,298,373,784.28	4,161,746,468.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,298,373,784.28	4,161,746,468.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,229,151,667.36	3,075,210,768.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,158,996,247.05	1,903,315,200.00
210101	Үндсэн цалин	719,855,696.27	1,194,811,917.32
210102	Нэмэгдэл	396,081,122.06	628,487,347.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	10,722,335.26
210104	Урамшуулал	18,426,153.64	29,156,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,633,275.08	40,137,100.00
210201	Тэтгэврийн даатгал	1,193,129.97	-
210202	Тэтгэмжийн даатгал	140,368.22	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	112,294.58	-
210204	Ажилгүйдлийн даатгал	28,073.67	-
210205	Эрүүл мэндийн даатгал	23,159,408.64	40,137,100.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	185,517,939.58	262,873,900.00
210301	Гэрэл, цахилгаан	111,253,846.58	155,355,600.00
210302	Түлш, халаалт	74,264,093.00	107,518,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	112,405,743.28	119,643,900.00
210401	Бичиг хэрэг	3,772,000.00	7,102,200.00
210402	Тээвэр, шатахуун	99,696,644.00	99,709,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,057,804.28	3,504,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	146,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,879,295.00	9,182,100.00
2105	Нормативт зардал	273,748,899.95	392,158,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,520,700.00	14,943,100.00
210502	Хоол, хүнс	253,228,199.95	377,215,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	206,160,320.00	177,501,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	80,929,900.00	19,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,249,900.00	5,077,400.00
210604	Урсгал засвар	122,980,520.00	153,423,900.00
2107	Томилолт, зочны зардал	-	2,465,400.00
210702	Дотоод албан томилолт	-	2,465,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	196,035,789.50	163,295,268.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	193,132,379.50	156,016,468.40
210803	Даатгалын үйлчилгээ	672,400.00	467,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	514,900.00	324,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	351,900.00	180,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	318,200.00	4,488,600.00
210807	Газрын төлбөр	1,046,010.00	1,818,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	177,216,628.00	60,486,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	176,579,728.00	59,850,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,222,116.92	1,086,535,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,649,900.00	1,067,735,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	232,671,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	823,072,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,649,900.00	11,990,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	479,934.96	500.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	479,934.96	500.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	61,092,281.96	18,800,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,092,281.96	18,800,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	129,589,978.50	21,385,842.37
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	128,289,200.00	6,530,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	128,289,200.00	6,530,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	128,289,200.00	6,530,000.00
220001	Барилга байгууламж	47,359,300.00	-
225102	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	80,929,900.00	6,530,000.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(128,289,200.00)	(6,530,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(3)+(6)+(7)	1,300,778.50	14,855,842.37
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,466,752.50	3,767,531.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,767,531.00	18,623,373.37

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,354,710,670.66	878,777,139.97	177,190,044.65	6,410,677,855.28
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,354,710,670.66	878,777,139.97	177,190,044.65	6,410,677,855.28
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн			708,207,061.97	708,207,061.97
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,354,710,670.66	878,777,139.97	885,397,106.62	7,118,884,917.25
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,354,710,670.66	878,777,139.97	1,593,604,168.59	7,118,884,917.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,354,710,670.66	878,777,139.97	885,397,106.62	7,118,884,917.25
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
D08	Тайлант үеийн үр дүн			(134,075,072.19)	(134,075,072.19)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,354,710,670.66	878,777,139.97	751,322,034.43	6,984,809,845.06

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,984,895,600.00	3,984,895,100.00	500.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,984,895,600.00	3,984,895,100.00	500.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,924,824,800.00	2,924,824,300.00	500.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,863,178,600.00	1,863,178,100.00	500.0
210101	Үндсэн цалин	1,103,680,500.00	1,194,811,917.32	(91,131,417.3)
210102	Нэмэгдэл	742,974,100.00	628,487,347.42	114,486,752.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,540,000.00	10,722,335.26	1,817,664.7
210104	Урамшуулал	3,984,000.00	29,156,500.00	(25,172,500.0)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,137,100.00	40,137,100.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	40,137,100.00	40,137,100.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	262,873,900.00	262,873,900.00	-
210301	Гэрэл, цахилгаан	155,355,600.00	155,355,600.00	-
210302	Түлш, халаалт	107,518,300.00	107,518,300.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	119,643,900.00	119,643,900.00	-
210401	Бичиг хэрэг	7,102,200.00	7,102,200.00	-
210402	Тээвэр, шатахуун	99,709,400.00	99,709,400.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,504,200.00	3,504,200.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	146,000.00	146,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,182,100.00	9,182,100.00	-

2105	Нормативт зардал	392,158,900.00	392,158,900.00	-	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,943,100.00	14,943,100.00	-	100.00
210502	Хоол, хүнс	377,215,800.00	377,215,800.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	137,501,300.00	137,501,300.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,000,000.00	19,000,000.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,077,400.00	5,077,400.00	-	100.00
210604	Урсгал засвар	113,423,900.00	113,423,900.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	2,465,400.00	2,465,400.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	2,465,400.00	2,465,400.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,378,800.00	46,378,800.00	-	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,100,000.00	39,100,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	467,900.00	467,900.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	324,100.00	324,100.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	180,000.00	180,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,488,600.00	4,488,600.00	-	100.00
210807	Газрын төлбөр	1,818,200.00	1,818,200.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,486,900.00	60,486,900.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59,850,000.00	59,850,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	636,900.00	636,900.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,060,070,800.00	1,060,070,800.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,060,070,800.00	1,060,070,800.00	-	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	232,671,800.00	232,671,800.00	-	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх	823,072,600.00	823,072,600.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,326,400.00	4,326,400.00	-	100.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,984,895,600.00	3,984,895,100.00	500.0	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,685,968,200.00	3,685,967,700.00	500.0	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,685,968,200.00	3,685,967,700.00	500.0	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	298,927,400.00	298,927,400.00	-	100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	298,927,400.00	298,927,400.00	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	94.00	91.00	3.0	96.81
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	93.00	90.00	3.0	96.77
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	94.00	91.00	3.0	96.31
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	94.00	91.00	3.0	96.31

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		40,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН		40,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		40,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		40,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		40,000,000.00
210604	Урсгал засвар		40,000,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		40,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		40,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		40,000,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /цаашид ШШГЕГ гэх /-ын харьяа 433 дугаар хаалттай хорих анги нь “Байгууллагын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэн, цахимжуулах ажлыг эрчимжүүлэх” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 267 дугаар зүйлийн 267.2-т хорих ангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасныг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хорих ялыг албадан эдлүүлэх,
- Хоригдлын аюулгүй байдлыг хангах, тэдний дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, хоригдол бусад этгээдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх,
- Хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх,
- Хоригдлыг хөдөлмөрлүүлэх, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд дадлага олгох,
- Хоригдлын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах,
- Бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчтэй, согтуурах, мансуурах донтох эмгэгтэй хоригдлыг албадан эмчлэх,
- Гэмт хэргийн улмаас хүн, хуулийн этгээдэд учруулсан хохирол, төлбөрийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгаж шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст шилжүүлэх, хорих байгууллагад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх,
- Хуульд заасан бусад чиг үүрэг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлт тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус хаалттай хорих ангийн санхүүгийн үйл ажиллагаанд ШШГЕГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүр шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн гүйцэтгэл болон байгууллагын харилцах дансны гүйлгээнд хяналт тавьж, үүрэг чиглэл өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих анги нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус хаалттай хорих анги нь ШШГЕГ-ын даргын 2020 оны А/134 дүгээр тушаалаар баталсан *“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”*-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих ангийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан *“Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”*-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 132,570.7 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,767.5	18,623.3	14,855.8
Авлага	9,147.6	-	(9,147.6)
Бараа материал	809,853.1	487,212.2	(322,640.9)
Үндсэн хөрөнгө	6,313,615.2	6,497,977.1	184,361.9
Нийт хөрөнгө	7,136,383.4	7,003,812.7	(132,570.7)
Өр төлбөр	17,498.5	19,002.9	1,504.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,118,884.9	6,984,809.8	(134,075.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,136,383.4	7,003,812.7	(132,570.7)

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 18,623.3 мянган төгрөг болж, 14,855.8 мянган төгрөгөөр өссөн нь төрийн сан дахь “Ахмадын сан”-ийн дансанд 22,985.9 мянган төгрөгийн хөрөнгө төвлөрүүлснээс,
- Бараа материал дансны үлдэгдэл 487,212.2 мянган төгрөг болж 322,640.9 мянган төгрөгөөр буурсан нь урсгал засварын үйл ажиллагаанд өмнөх оны үлдэгдлээс 332,525.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,497,977.1 мянган төгрөг болж 184,361.9 мянган төгрөгөөр өссөн нь систем хоорондын шилжүүлгээр 96,231.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан зэргээс голлон шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус анги нь 2023 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,529,847.9 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 298,927.4 мянган төгрөг, нийт зарлагыг 3,828,775.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчаас хүргүүлсэн төсвийн төслийн саналаас цалингийн зардлыг 288,283.9 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 39,997.4 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 34,728.4 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 339,125.1 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 168,434.1 төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 96,672.0 мянган төгрөгөөр, бараа, үйлчилгээний бусад зардлыг 39,151.5 мянган төгрөгөөр тус тус бууруулж 2,822,382.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсөвт хангамж, бараа материалын зардлыг 102,441.9 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 1,060,070.8 мянган төгрөгөөр

зэрэг нийт 1,162,512.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн төсвийн тодотгол, зохицуулалт хийж, 3,984,895.6 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,685,968.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 298,927.4 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,685,968.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосж, туслах үйл ажиллагааны орлогоор 298,927.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,984,895.1 мянган төгрөг буюу 100 хувьтай тайлагнагдсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	2,924,824.8	2,924,824.3	(0.5)	100
2	Туслах үйл ажиллагаа	203,477.4	203,477.4	-	100
3	Шүүхийн шийдвэрийн үйлдвэрлэлийн арга хэмжээ	95,450.0	95,450.0	-	100
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,060,070.8	1,060,070.8	-	100
	Нийт	3,984,895.6	3,984,895.1	(0.5)	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус хаалттай хорих ангийн нэмэлт санхүүжилтийн дансанд ШШГЕГ-аас төсөл, арга хэмжээний санхүүжилт 40,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрснийг хоригдлын байр болон уурын зуухны засварын ажлуудад зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Хүнсний материал /Мах, махан бүтээгдэхүүн-72,731.6 мянган төгрөг/	377,215.8	377,215.8	НТШ
2	Хүнсний материал /Хуурай хүнс-55,298.4 мянган төгрөг/			НТШ
3	Хүнсний материал /Гурил-60,790.0 мянган төгрөг/			
4	Нүүрс	107,518.3	107,518.3	НТШ
5	Шатахуун, шатах тослох материал	99,709.4	99,709.4	НТШ
	Нийт дүн	584,443.5	584,443.5	

Хоол, хүнсний материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 4 удаа, нүүрсний худалдан авалтын нээлттэй тендерийг 3 удаа зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй тул тендер шалгаруулалтын аргыг өөрчлөн харьцуулалтын аргаар зарлахад дахин оролцогч ирээгүй байна. Иймд өмнөх онуудад гэрээний үндсэн дээр бэлтгэн нийлүүлэлт хийж байсан Монночикон ХХК, Уужим хараа ХХК, Хараа мөнгилмаа ХХК, Ноцох дөл ХХК-тай гэрээ байгуулан түлээ нүүрс, хоол хүнсний худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримтын хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих ангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/68 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,332,807.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 23,328.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд тус ангийн батлагдсан төсөвт материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 4,445,645.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон **44,456.4** мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус анги нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Ангийн үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, кино контент, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Ангийн данс бүртгэлд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар сольсон,
- Үндсэн болон шуурхай үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаанд зориулан гар утасны зардал гаргаагүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан,
- Зах зээлийн үнийн өсөлтөөс шалтгаалахгүйгээр бараа бүтээгдэхүүнийг гэрээний үнээр худалдан авсан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

ШШГЕГ-ын харьяа 433 дугаар хаалттай хорих анги нь мэдээлбэл зохих 28 тэрлийн 168 мэдээллийг хугацаанд нь, бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд тус ангийн үйл ажиллагаанд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус ангийн 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 168,822.1 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын шинж чанартай ажлын зургийг мэргэжлийн бус байгууллагаар гүйцэтгүүлсэн, хандивын орлого төвлөрүүлж, зарцуулсан, авлага, өр төлбөр үүсгэсэн зэрэг зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, шаардах хуудсыг холбогдох тушаалтнаар баталгаажуулалгүйгээр нярав зардал гаргасан болон шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг 2 зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 96.3 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	5,250.0	1	5,250.0	100
	1	10,626.1	1	8,656.0	81.5
	1	152,946.0	1	152,946.0	100
Зөвлөмж	1	-	1	-	100
	1	-	1	-	100
Нийт дүн	5	168,822.1	4	166,852.0	96.3

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **26,089.4** мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад бүрэн залрууллаа. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн шинж чанартай тайга хөрөө, өндөр даралтын насос, хяналтын камер зэрэг 25,168.6 мянган төгрөгийн өртөг бүхий 4 хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн,
- Санхүүгийн байдлын тайлангийн машин тоног төхөөрөмжийн тайлант оны эхний үлдэгдэл өмнөх оны эцсийн үлдэгдлээс 920.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.

Аудитаар нийт **25,949.0** мянган төгрөгийн 4 зөрчил² илэрч, 1,907.1 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 24,041.9 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгөв.

5.1 Албан шаардлага

1. Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас ХХОАТ-ын **1,907.1** мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *“Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоог урьдчилан хянаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь *“... байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах.....”*, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан *“Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэсэн заалтын дагуу Ахмадын сангийн эх үүсвэрийг төсөвт тусган төлөвлөөгүйгээс жилийн эцэст цалингийн зардлаас **22,985.9** мянган төгрөгийг төрийн сан дахь “Ахмадын сан”-ийн 100130412506 дугаар дансанд шилжүүлсэн байна.*

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь заалтыг хэрэгжүүлэн тухайн жилийн төсвийн төлөвлөгөөнд “Ахмадын сан”-ийн зардлыг тусган, батлуулах.

2.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн, эдийн засгийн ангиллаар үнэн зөв төлөвлөөгүй, төсвийн зохицуулалт хийх саналыг тухай бүр хүргүүлээгүйгээс бараа ажил, үйлчилгээний бусад зардлаас урсгал засварын зардалд 1,056.0 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2: “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх”, 42 дугаар зүйлийн 42.3.1 дэх “Төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид, ...хүргүүлэх”. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөх, шаардлагатай тохиолдолд төсөвт зохицуулалт хийлгэж байх.

2. Анхан шатны баримттай холбоотой асуудал:

3.1 Илрүүлэлт: Бүрдэл дутуу анхан шатны баримтаар дараах ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- Фото зураг болон малын эмчийн тодорхойлолтын бүрдэлгүйгээр малын устгалын акт үйлдэж, данс бүртгэлээс хассан,
- Жолоочийн тооцооны хуудсанд ирсэн, явсан болон зарцуулсан хугацаа, спидометрийн заалтыг бүрэн хөтлөөгүй,
- Түлш, шатахууны зарцуулалтыг автомашин ашигласан албан тушаалтны гарын үсгээр бус жолоочийн гарын үсэг зурсан тооцооны хуудсаар хянаж, бүртгэл тайланд тусгасан,
- Хүнс, түлш шатахуун, сэлбэг хэрэгсэл, хоригдлуудын ахуйн хангалт зэрэг бараа материалын орлого, зарлагын баримт болон шаардах хуудсыг холбогдох албан хаагчдын гарын үсгээр бүрэн баталгаажуулаагүй.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж

ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 3.3, 3.6, 6.4 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн хөдлөл өөрчлөлт бүрийг холбогдох албан тушаалтнуудын гарын үсгээр баталгаажуулан, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн.	1	25,168.6			1	25,168.6	1	25,168.6				
Тоног төхөөрөмжийн эхний үлдэгдлийг зөрүүтэй илэрхийлсэн	1	920.8			1	920.8	1	920.8				
Дүн	2	26,089.4			2	26,089.4	2	26,089.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Авлага, өр төлбөр үүсгэсэн.	1	1,907.1			1	1,907.1						
Төсвийг үнэн зөв төлөвлөөгүй	2	24,041.9					2	24,041.9				
Бүрдэл дутуу анхан шатны баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэсэн	1						1	-				
Дүн	4	25,949.0			1	1,907.1	3	24,041.9				

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.